



МОНГОЛ УЛСЫН
ЗАСГИЙН ГАЗАР

БАРИЛГА, ХОТ
БАЙГУУЛАЛТЫН ЯАМ

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,
ДОТООД АУДИТЫН ГАЗАР

**БХБЯ-НЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН 2022 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ
/хагас жилийн байдлаар/**

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

БХБЯ-ны ТШЗ-ийн 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт- 91.4

№	Газрууд	Зорилтын тоо	Нийт арга хэмжээ	Хэрэгжилт хувиар						ХБ	Биелэлтийн дүн
				100%	90%	70%	50%	30%	0%		
1	Бодлого, төлөвлөлтийн газар	5	57	42	4	7	2	2	-		91.6%
2	Хот байгуулалт, газрын харилцааны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	7	77	44	17	11	3	2	-		90.6%
3	Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар	9	69	44	-	7	8	10	-		82.5%
4	Нийтийн аж ахуй, инженерийн дэд бүтцийн бодлогын хэрэгжилтийн газар	4	55	42	-	7	2	4	-		89.2%
5	Санхүү, хөрөнгө оруулалтын газар	5	31	23	3	2	2	1	-		91.6%
6	Төрийн захиргааны удирдлагын газар	13	65	57	6	2	-	-	-		97.2%
7	Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар	10	53	43	-	4	-	-	-	6	97.4%
	Дүн	53	407	295	30	40	17	19	0	6	91.4



БОДЛОГО ТӨЛӨВЛӨЛТИЙН ГАЗАР- 91,6%

Хэрэгжилт “Эрчимжүүлэх шаардлагатай” 50 хувийн биелэлттэй дараахь 3 ажил байна. Үүнд:

- 1.3.9. Монгол Улсын Барилга, хот байгуулалтын яам Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Орон сууц, хот-хөдөөгийн хөгжлийн яам хооронд байгуулсан санамж бичгийн хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.
- 1.3.17. Бүгд Найрамдах Беларус Улстай барилга, архитектурын төлөвлөлтийн чиглэлээр хамтын ажиллагааг эхлүүлнэ.

Хэрэгжилт “Үр дүнгүй” 30 хувийн биелэлттэй дараах 2 ажил байна. Үүнд:

- 1.4.4. Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци байгуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, корпорацийг шинээр байгуулна.
- 1.5.1. “Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл”-ийг хэрэгжүүлэх нэгжийг мэргэшил, арга зүйгээр ханган ажиллаж, төслийн хэрэгжилтийг хангуулна.



ХОТ БАЙГУУЛАЛТ, ГАЗРЫН ХАРИЛЦААНЫ БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗАР- **90,6%**

Хэрэгжилтийг эрчимжүүлэх шаардлагатай, 50 хувьтай 3 арга хэмжээ байна. Үүнд:

- 2.4.4. Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээлэл, газрын биржийн удирдлагын нэгдсэн төв байгуулж, газрын харилцаатай холбоотой орон зайн өгөгдөл, мэдээллийн хүртээмжийг нээлттэй, ил тод болгох ажлыг зохион байгуулна.
- 2.5.2. Хот, суурины ногоон байгууламжийн тухай хуулийн төсөл боловсруулах ажлыг зохион байгуулна.
- 2.7.11. Цагааннуур чөлөөт бүсийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулна.

Бэлтгэл ажлууд хийгдэж байгаа 30 хувьтай 2 арга хэмжээ байна. Үүнд:

- 2.7.12. Их тэнгэр цогцолбор байрлаж буй Богдхан уулын Их тэнгэрийн амны хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг зохион байгуулна.
- 2.6.9. Бүсийн тулгуур төвүүдийн батлагдсан хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулна.



БАРИЛГА, БАРИЛГЫН МАТЕРИАЛЫН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗАР- **82,5%**

Хэрэгжилт “Эрчимжүүлэх шаардлагатай” 50 хувийн биелэлттэй дараах 8 ажил байна. Үүнд:

- 3.1.6. Барилга байгууламжийг хүчитгэх эрх зүйн орчинг шинэчлэн сайжруулсан байна.
- 3.2.1. Барилга байгууламжийн аюулгүй байдлын техникийн зохицуулалтын баримт бичгийг Засгийн газарт хүргүүлнэ.
- 3.2.2. Барилга, байгууламжийн галын аюулгүй байдлын техникийн зохицуулалтын баримт бичгийг Засгийн газарт хүргүүлнэ.
- 3.2.6. “Барилгын буулгах арга технологи, хаягдлыг зайлуулах зохион байгуулалт” (БНБД)-г боловсруулах ажлыг зохион байгуулна.
- 3.5.1. Барилгын материалын түүхий эдийн орд, илэрцийн хайгуулыг эрчимжүүлж бүс нутгуудад үйлдвэр байгуулах түвшинд нөөц тогтоох хууль эрхзүйн орчныг бүрдүүлнэ.
- 3.7.8. Гол нэр төрлийн зарим барилгын материал үйлдвэрлэгч ААНБ-уудын үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудтай хамтран хяналт шалгалтыг зохион байгуулна.
- 3.8.3. Жайка ОУХАБ-тай хамтран “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй” 2 дугаар төслийг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах.
- 3.9.5. Барилга байгууламжийн зураг төсөл боловсруулах үе шатны иж бүрдлийг тодорхойлох баримт бичиг боловсруулна.

Хэрэгжилт “Үр дүнгүй” 30 хувийн биелэлттэй дараахь 10 ажил байна. Үүнд:

- 3.1.9. Барилгын зураг төслийн экспертиз, магадлалын үйл ажиллагааны төвлөрлийг задалж, хөндлөнгийн тогтолцоонд шилжүүлэн нэг үе шаттай болгон хэрэгжүүлнэ.
- 3.2.10. “Барилга угсралтын ажлыг гүйцэтгэсэн тэмдэглэл”-ийг шинэчлэн боловсруулах ажлыг эхлүүлэх
- 3.2.11. Барилга угсралтын ажлын ил, далд ажлын актыг боловсруулах ажлыг эхлүүлэх
- 3.4.6. Паспортжуулалт, гэрчилгээжүүлэлтэд заавал хамрагдах шаардлагатай онцгой зориулалт бүхий барилгуудын жагсаалтыг гаргаж батлуулах арга хэмжээг авсан байна.
- 3.5.2. Эрдэнэтийн гангийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчилж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг жигдэрүүлнэ.
- 3.7.2. “Барилгын материалын туршилт, шинжилгээ, судалгааны ажил эрхлэх нэгдсэн лабораторийн дүрэм”-ийг шинэчлэн батлуулна.
- 3.8.4. Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын 1988 оны “Барилгын аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай” 167 конвенцийг хэрэгжилтийн тайлан боловсруулах.
- 3.9.1. Барилгын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг үзэл баримтлалыг боловсруулж, ХЗДХЯ-нд хүргүүлнэ.
- 3.9.2. Барилгын үйл ажиллагаанд холбогдсон зөвшөөрөл олгох хүсэлтийг цахимаар хүлээн авч шийдвэрлэх болон барилгын салбарт нэг цэгийн үйлчилгээ үзүүлэх нийтлэг журмын төслийг боловсруулан, батлуулна.
- 3.9.4. Барилга байгууламжийн эдэлгээний жишиг хугацааг тогтоох дүрмийг барилгын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.



НИЙТИЙН АЖ АХУЙ, ИНЖЕНЕРИЙН ДЭД БҮТЦИЙН БОДЛОГЫН ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗАР- 89,2% **Хэрэгжилт хангалтгүй, 50 хувьтай 2 арга хэмжээ байна.**

- 1. Арга хэмжээ 4.3.15. Аймгийн төв, суурин газрын 8 цэвэрлэх байгууламжийг шинэчлэх, шинээр барих төслийг үе шаттай хэрэгжүүлнэ. /Баян-Өлгий, Дорнод, Говьсүмбэр, Завхан, Увс, Говь-Алтай, Баянхонгор аймгуудын төв болон Улаанбаатар хотын Багануур дүүрэг/ МУХОХ-123, ЗГҮАХХАХТ-3.7.11.6/. *Зорилтот түвшин: Төслийн хэрэгжилт -30%*
- 2. Арга хэмжээ 4.3.17. БНФУ-ын зээлээр хэрэгжсэн “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх” төслийг дуусгаж ашиглалтад оруулах. *Зорилтот түвшин: Төслийн хэрэгжилт - 100%*

Хэрэгжилт хангалтгүй, 30 хувьтай арга хэмжээ 4 байна.

- 1. Арга хэмжээ 4.3.14. АХБ-ны зээлээр хэрэгжүүлж буй Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төслийг хэрэгжүүлэх. *Зорилтот түвшин: Төслийн хэрэгжилт -100%*
- 2. Арга хэмжээ 4.3.22. Налайхын барилгын материалын үйлдвэрлэл технологийн паркийн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламжийг шинээр барих ажлыг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллах. *Зорилтот түвшин: Төслийн хэрэгжилт -10%*
- 3. Арга хэмжээ 4.3.26. Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн лагийг боловсруулах, үнэргүйжүүлэх арга хэмжээний дараагийн үе шат болох лаг хатаах байгууламжийг барихад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэх. *Зорилтот түвшин: Инженерийн хангамжид холбогдох гэр хорооллын өрх-10%*
- 4. Арга хэмжээ 4.4.2. Хамтын хэлэлцээрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг хэрэгжүүлэн ажиллах. *Зорилтот түвшин: Төлөвлөгөөг дүгнэсэн байна.*

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗАР- 91,6%

Хэрэгжилт хангалтгүй, 50 хувьтай 2 арга хэмжээ байна.

- 1.1. Салбарын эдийн засгийн хүндрэлтэй нөхцөл байдалд үнэлгээ, дүгнэлт хийж, салбарын санхүү, эдийн засгийн төлөвлөлт, хөрөнгө оруулалтын үр дүнг дээшлүүлэх бодлого боловсруулж, хэрэгжүүлнэ. *Зорилтот түвшин: судалгаа хийж тайлан боловсруулна.*
- 3.3.Төсвийн гүйцэтгэл тайлан болон 5.0 сая төгрөгөөс дээш гүйлгээг Шилэн дансны цахим мэдээллийн хуудсанд хуулийн хугацаанд байршуулна. *Зорилтот түвшин:шилэн данс болон яамны цахим хуудсанд мэдээллийг оруулах*

Хэрэгжилт хангалтгүй, 30 хувьтай арга хэмжээ 1 байна. Үүнд:

- 1.5. Мөнгө угаахтай тэмцэх санхүүгийн арга хэмжээг хэрэгжүүлэх олон улсын байгууллагаас мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр гаргасан зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд байгууллагын санхүүгийн эрсдэлийн үнэлгээг хийлгэж, илэрсэн эрсдэлийг бууруулах арга хэмжээг авна. *Зорилтот түвшин: санхүүгийн эрсдэлийн үнэлгээг хийлгэж, бодлого боловсруулна.*

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ГАЗАР- 97,2%

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ДОТООД АУДИТЫН ГАЗАР- 97,4%

”Эрчимжүүлэх шаардлагатай” болон “Үр дүнгүй” үнэлэгдсэн арга хэмжээ байхгүй болно.



Санал, зөвлөмж

1. Засгийн газрын 2020 оны 217, 218-р тогтоолын хавсралтаар баталсан “Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн зорилт, шалгуур үзүүлэлтийг тогтоох, тайлан гаргах журам” болон “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 тоот тушаалын 7 дугаар хавсралт “Байгууллага болон зохион байгуулалтын нэгжийн гүйцэтгэлийн тайлангийн загвар”-ын шаардлагад нийцүүлэн, шалгуур үзүүлэлт, хүрэх түвшинтэйгээ уялдуулан, товч тодорхой, 2000 тэмдэгтэд багтаан тайлагнах;

/БТГ, ББТҮБХЗГ, ХБГХБХЗГ, НААИДББХЗГ, ТЗУГ, СХОГ/

2. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний “**Үр дүнгүй**” хэрэгжилттэй 1.4.4, 1.5.1 дэх 2 арга хэмжээ, “**Эрчимжүүлэх шаардлагатай**” 1.3.9. 1.3.17, дэх 2 арга хэмжээ, нийт 4 арга хэмжээнд анхаарч, ажиллах;

БТГ, Б.Гүнболд

3. “1.5.1. “Ногоон нуур 1008 айлын орон сууц төсөл”-ийг хэрэгжүүлэх нэгжийг мэргэшил, арга зүйгээр ханган ажиллаж, төслийн хэрэгжилтийг хангуулна” арга хэмжээ нь ТНБД-ын 2022 оны 02-р сарын 21-ны А/69 дугаар тушаалаар 2022 оны А/02 дугаар тушаалын хавсралтаар “Гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй Төслийн захирлуудын нэрс” жагсаалтын 14-т заасан “Бодлого, төлөвлөлтийн газрын дарга”, гэснийг “Барилга, барилгын материалын үйлдвэрлэлийн бодлого зохицуулалтын газрын дарга” гэж өөрчилсөнтэй холбогдуулан газрууд 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд өөрчлөлт оруулаагүйгээс хэрэгжилт хангагдахгүй, ажил цалгардах байдал үүсэж байгаа тул өөрчлөлт оруулан батлуулахад анхаарах;

БТГ, Б.Гүнболд, ББМҮБХЗГ, Д.Гантулга

4. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 50 хувьтай 3, 30 хувьтай 2 арга хэмжээнүүдийн хэрэгжилтийг хангах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулж, сүүлийн хагас жилд бүрэн хэрэгжүүлж ажиллах;

ХБГХБХЗГ, Ц.Баярбат



Санал, зөвлөмж

5. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний “Үр дүнгүй” хэрэгжилттэй 3.1.9, 3.2.10, 3.2.11, 3.4.6, 3.5.2, 3.7.2, 3.8.4, 3.9.1, 3.9.2, 3.9.4 дэх 10 арга хэмжээ, “Эрчимжүүлэх шаардлагатай” 3.1.6, 3.2.1, 3.2.2, 3.2.6, 3.5.1, 3.7.8, 3.8.3, 3.9.5 дахь 8 арга хэмжээ, нийт 18 арга хэмжээнд анхаарч, ажиллах;

ББМҮБХЗГ, Д.Гантулга

6. Тус газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд туссан хэрэгжилт хангалтгүй, 30-50 хувьтай 6 арга хэмжээг бүрэн хэрэгжүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээг 2022 оны сүүлийн хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх;

НААИДББХЗГ, ИДБХ Б.Цогтсайхан, Д.Мөнхбаатар

7. Орон сууцны ашиглалтын тухай хууль болон дагалдан гарах дүрэм, журмыг яаралтай батлуулан, салбарын хууль, эрх зүйн орчныг сайжруулах арга хэмжээ авах;

НААИДББХЗГ, ИДБХ Б.Цогтсайхан, Д.Мөнхбаатар

8. АХБ-ны зээлээр хэрэгжүүлж буй Дархан хотын бохир усны менежментийг сайжруулах төсөл болон БНПольш Улсын нөхцөлт зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй “Баян-Өлгий, Увс, Завхан, Говьсүмбэр, Дорнод аймгийн цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх төслийн хэрэгжилтийг эрчимжүүлэх; БНФрУ-ын зээлээр хэрэгжсэн “Эрдэнэт хотын бохир ус цэвэрлэх байгууламжийг өргөтгөн шинэчлэх” төслийг дуусгаж ашиглалтад оруулах; аймаг бүрт гэр хорооллын 600-аас доошгүй өрхийг инженерийн хангамжид холбох болон Улаанбаатар хотын төв цэвэрлэх байгууламжийн лагийг боловсруулах, үнэргүйжүүлэх арга хэмжээний дараагийн үе шат болох лаг хатаах байгууламжийг барихад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг шийдвэрлүүлэхэд чиглэсэн тодорхой арга хэмжээг 2022 оны сүүлийн хагас жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлэх;

НААИДББХЗГ, ИДБХ Б.Цогтсайхан, Д.Мөнхбаатар



Санал, зөвлөмж

9. Хот суурины хүн ам, үйлдвэр, аж ахуйн газруудыг стандартын шаардлага хангасан цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир усыг татан зайлуулж, цэвэрлэх үйлчилгээний тусгай зөвшөөрөл олгох, цэвэр, бохир усны үнэ тарифыг хянан баталгаажуулах зэрэг салбарын үндсэн үйл ажиллагааг зохицуулах, зохион байгуулах чиг үүрэг бүхий ХСУХАТАҮЗохицуулах Зөвлөлтэй нягт хамтран ажиллаж, салбарт тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх нарийвчилсан төлөвлөгөө батлуулан, хэрэгжүүлэн ажиллах зөвлөмжийг хүргүүлж байна.

НААИДББХЗГ, ИДБХ Б.Цогтсайхан, Д.Мөнхбаатар

10. Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах; СХОГ Э.Ганхүү

- Шилэн дансны тухай хуулийн хугацаанд багтаан шаардлага хангасан мэдээллийг үнэн зөв, иж бүрэн байршуулж, ил тод байдлыг ханган ажиллах,
- Shilendans.gov.mn сайтад ТНБД-ын 2021 оны 02-р сарын 08-ны А/12 дугаар тушаалаар батлагдсан чиг үүргийн дагуу газрын мэргэжилтнүүд мэдээллийг байршуулах;

Санал, зөвлөмж

11. БХБСайдын зөвлөлийн 2022 оны 06 дугаар сарын 13-ны өдрийн хуралдаанаас өгсөн үүрэг даалгаварын дагуу “Монгол Улсын хөгжлийн 2022 оны төлөвлөгөөнд туссан боловч санхүүжилтийн эх үүсвэр шийдэгдээгүйн улмаас хэрэгжилт хангалтгүй дараах 5 арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг” Төрийн нарийн бичгийн даргын Б/127 тоот тушаалаар батлагдсан үндсэн чиг үүргийн хүрээнд улс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээс шийдвэрлүүлэх боломжийг судлан, холбогдох газруудтай хамтран санал боловсруулан танилцуулж, шийдвэрлүүлэх;
СХОГ Э.Ганхүү

- Барилгын хавтгай шилний үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлэх - *72,0 тэрбум төг;*
- Монгол Улсын нутаг дэвсгэрийн 55 хувийг 1:25 000 масштабтай байр зүйн зургаар зурагжуулах - *24,0 тэрбум төг;*
- Барилга байгууламжийг паспортжуулах, /405 барилга/ - *820,0 сая.төг*
- Мониторингийн сүлжээний 3000 цэгт газрын төлөв байдал, чанарын судалгааг хийж, хөрсний хяналт-шинжилгээний улсын 1 лабораторийг Төвийн бүсэд байгуулах - *92,0 сая төг;*
- “Дэнжийн мянга дэд төв”, “Дамбадаржаа дэд төв” төслийг хэрэгжүүлэх - *20,0 тэрбум төг;*

12. Ажилтан албан хаагчдын ажлын байрны хэвийн нөхцөл, ажиллах орчны таатай нөхцөлийн талаар санал асуулга авч, асуулгын дүнгийн мөрөөр зохих арга хэмжээг авч ажиллах;

ТЗУГ Д.Баярсайхан

13. Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 70 хувьтай 2 арга хэмжээний хэрэгжилтийг хангах талаар тодорхой ажлуудыг зохион байгуулж, сүүлийн хагас жилд бүрэн хэрэгжүүлж ажиллах;

ТЗУГ Д.Баярсайхан



Санал, зөвлөмж

14. Газрууд гүйцэтгэлийн төлөвлөгөөндөө ЗГҮАХ-ийн арга хэмжээнүүдийг тусгахдаа тухайн оныхоо зорилтот түвшинтэй уялдуулаагүй, зөрүүтэй төлөвлөснөөс шалтгаалан ЗГҮАХ-т туссан зарим арга хэмжээний хэрэгжилт хангалтгүй байгаад анхаарч, 2022 оны төлөвлөгөөндөө тодотгол хийж, нэг зорилтот түвшинтэйгээр жилийн эцсийн биелэлтийг гарган ирүүлэхийг ЗӨВЛӨМЖ болгосугай;

/БҮХ ГАЗАР, ХЭЛТСҮҮДЭД/

Түүнчлэн ЗГҮАХ-өтөлбөрт туссан 2022 оны зорилтот түвшингээс зөрүүтэй төлөвлөсөн нийтлэг дутагдал байна. Тухайлбал: Газар бүрээс жишээ авч харуулав.



№	Арга хэмжээ	ЗГҮАХ-ийн 2022 оны зорилтот түвшин	Газруудын ГТ-нд туссан зорилтот түвшин	Хариуцах газар
1	3.7.3.5. Байрлалд суурилсан орон зайн өгөгдөл, мэдээлэл, газрын биржийн удирдлагын нэгдсэн төв байгуулж, газрын харилцаатай холбоотой орон зайн өгөгдөл, мэдээллийн хүртээмжийг нээлттэй, ил тод болгоно.	Нэгдсэн төвийг байгуулах ажлыг эхлүүлнэ. Үнэлгээ-0	/Арга хэмжээ 2.4.4./ ТЭЗҮ боловсруулах ажлын зардлын тооцоог батлуулсан байна. Үнэлгээ- 50	ХБГХБ ХЗГ
2	3.7.13.1. Эрдэнэтийн гангийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийг шинэчилж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг жигдэрүүлнэ.	Арматур цувах, ган утас үйлдвэрлэх шугамыг барьсан байна. Үнэлгээ-0	/Арга хэмжээ 3.5.2./ Засгийн газрын тогтоол гаргана. Хөрөнгө оруулалтыг шийдвэрлэх асуудлаар Хөгжлийн банктай хамтран ажилласан байна. Үнэлгээ-30	ББМҮБХ ЗГ
3	3.7.8.1. Үндэсний орон сууцны нэгдсэн корпораци байгуулах хууль, эрх зүйн орчинг бүрдүүлж, корпорацийг шинээр байгуулна.	Үндэсний орон сууцны нэгдсэн корпорацийг шинээр байгуулж, үйл ажиллагааг эхлүүлнэ. Үнэлгээ-30	/Арга хэмжээ 1.4.4./ Холбогдох талуудтай хамтран Үндэсний орон сууцны корпораци байгуулах асуудлаар шийдвэрийн төсөл боловсруулсан байна. Төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, холбогдох шийдвэрийг гаргуулсан байна. Үнэлгээ-30	БТГ
4	5.1.4.1. Гэр хорооллын нүхэн жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлнэ.	Улаанбаатар хот болон төв суурин газрын 2000-аас доошгүй жорлонг үе шаттайгаар стандартын шаардлагад нийцүүлсэн байна. Үнэлгээ-50	Гэр хорооллын нүхэн жорлонг стандартын шаардлагад нийцсэн жорлонгоор солих ажлын худалдан авах ажиллагааг эхлүүлж гэрээ байгуулсан байна. Үнэлгээ-100	НААИДБ БХЗГ

АНХААРАЛ ХАНДУУЛСАНД БАЯРЛАЛАА

Харилцах хаяг:

Засгийн газрын байр 12, Барилгачдын талбай-3

Улаанбаатар 15170, Монгол Улс

Утас: (976)-76003333 (1191)

Факс: (976)-11-322904

www.m cud.gov.mn